

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр¹-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.42-д “Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, кино ны тухай, музейн тухай хуулийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ” гэж заасан.

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд уг хуулийн төслийн зарим хэм хэмжээгээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэн гэсэн субъект тус бүрт хамаарах зохицуулалт нэг бүрээр тооцон гаргана.²

1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэхэд “төрийн захиргааны байгууллагад үүсэх ачааллыг зардлыг тодорхойлохдоо дараахь үе шаттай ажиллагаа хийлээ. Үүнд:

1. Үүргийг тогтоох
2. Хүний нөөцийг тогтоох
3. Гарах зардлыг тооцох
4. Зардлыг нэгтгэн тооцож гаргах
5. Хувилбарыг нягтлах, үр дүнг танилцуулах

Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт кино бүтээх үйл ажиллагаанд оролцогчдын талаар зохицуулсан байна. Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудад дараахь байгууллагууд орно. Үүнд:

1. Засгийн газар (Төслийн 4 дүгээр зүйл)
2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Төслийн 5 дугаар зүйл)
3. Төрийн захиргааны байгууллага (Төслийн 6 дугаар зүйл)
4. Аймаг, нийслэлийн Засаг дарга (Төслийн 7 дугаар зүйл)

1.1 Үүрэг хүлээх байгууллагууд болон тэдгээрийн гүйцэтгэх үүргүүд

Монгол Улсын нутаг дэвсгэрт кино бүтээх, түгээх, борлуулах, кино үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотойгоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Соёлын тухай³, Соёлын өвийг хамгаалах тухай⁴ зэрэг хуулиудтай Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг харьцууллаа. Харьцуулалтаас төрийн байгууллагын гүйцэтгэж буй үүрэгт өөрчлөлт орсон, чиг үүрэг нэмэгдсэн зохицуулалт хуулийн төсөлд байгаа тохиолдолуудыг түүвэрлэв.

Хүснэгт №1 – АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

¹ <http://legalinfo.mn/law/details/12120?lawid=12120>

² Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 239

³ <http://legalinfo.mn/law/details/454?lawid=454>, 1996 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан.

⁴ <http://legalinfo.mn/law/details/10439?lawid=10439>, 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан.

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Гүйцэтгэх үүрэг
Засгийн газар	Кино урлагийг хөгжүүлэх, кино үйлдвэрлэлийн дэд бүтэц байгуулах (Төслийн 4.1.1 дэх заалт) Киноны салбарын уран бүтээлчдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр батлах (Төслийн 4.1.1 дэх заалт)	<ul style="list-style-type: none"> - Бодлогоор кино урлагийг хөгжүүлэх - кино үйлдвэрлэлийн дэд бүтэц байгуулах - хөтөлбөр батлах
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Киноны талаар төрөөс баримтлах бодлого, киноны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах (Төслийн 5.1.1 дэх заалт) Уран бүтээлийн төсөл болон хамтарсан кино бүтээхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий кино мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг батлах (Төслийн 5.1.2 дахь заалт) Кино түгээгчид тусгай зөвшөөрөл олгох (Төслийн 5.1.3 дахь заалт) Гадаад кино, хамтарсан кинонд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авах зөвшөөрөл олгох журам батлах (Төслийн 5.1.4 дэх заалт)	<ul style="list-style-type: none"> - хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах - Кино мэргэжлийн Зөвлөлийн ажиллах журам боловсруулж, батлах - Тусгай зөвшөөрөл олгох - Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авах зөвшөөрөл олгох журам боловсруулж батлах
Төрийн захиргааны байгууллага	Кино үзвэрийн байгууллагын хүртээмжтэй бүтцийг бий болгох зохион байгуулалтын арга хэмжээ авах (Төслийн 6.1.1 дэх заалт) Киноны мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг үзүүлэх (Төслийн 6.1.2 дахь заалт) Олон улсын кино наадам, арга хэмжээг эх орондоо зохион байгуулах (Төслийн 6.1.3 дахь заалт) Төрөөс санхүүжүүлсэн кинонд хяналт тавьж ажиллах (Төслийн 6.1.4 дэх заалт) Киноны салбарын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулж, киноны мэдээллийн санг бүрдүүлэх (Төслийн 6.1.5 дахь заалт)	<ul style="list-style-type: none"> - хүртээмжтэй бүтэц бий болгох зохион байгуулалтын арга хэмжээ авах - мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг үзүүлэх - төрөөс санхүүжүүлсэн кинонд хяналт тавьж ажиллах - статистикийн мэдээллийг боловсруулж, дүн мэдээг нэгтгэх, - киноны мэдээллийн санг бүрдүүлэх
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Киноны тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн хэмжээнд кино түгээх үйл ажиллагааг дэмжиж ажиллах (Төслийн 7.1 дэх хэсэг)	<ul style="list-style-type: none"> - хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах - кино түгээх үйл ажиллагааг дэмжих

Кино урлагийг дэмжих зорилгоор дараах зардлуудыг санхүүжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 3.2.46-т зааснаар "Жил бүр үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхийн сэдэвтэй кино, тайз дэлгэц, утга зохиолын томоохон хэмжээний мэргэжлийн түвшний 1 бүтээл

туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ” гэж заасан тул дараах кинонд дэмжлэг үзүүлэхээр тусгасан.

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт: 3.2.46. Жил бүр үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхийн сэдэвтэй кино, тайз дэлгэц, утга зохиолын томоохон хэмжээний мэргэжлийн түвшний 1 бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ: Жил бүр улсын захиалгаар түүхэн сэдэвт уран сайхны, бүрэн хэмжээний кино туурвих

Хугацаа: 2017-2020

Эх үүсвэр: Улсын төсөв

Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг): 4,500.0

Жил бүр улсын төсвөөс зарцуулах хөрөнгө: 1,500.0

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан кинонд үзүүлэх дэмжлэг хэсэгт заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцоо:

1. 108,9 сая төгрөг - Монгол улсын түүхэнд холбогдох онцлог үйл явдал, он дарааллын түүхийн талаархи баримтат кино бүтээх зардлыг улсын төсвөөс жил бүр санхүүжүүлж байна.
2. 500 саяас 1.5 тэрбум төгрөг – түүхийн сэдэвтэй уран сайхны кино бүтээхэд гарах зардал
3. хүүхдэд зориулсан уран сайхны 1 кино бүтээхэд дунджаар 200,0 сая төгрөг, 5 кино бүтээхэд 1,0 тэрбум төгрөг
4. Киноны мэргэжилтэн, боловсон хүчин гадаадад бэлтгэхэд 1 хүн 50,0 сая 10 хүн 500,0 сая төгрөг
5. Киноны дэд бүтэц бүтээн байгуулахад дэмжлэг үзүүлэхэд 1-5 тэрбум төгрөг болохоор байна.

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан баримтат кинонд үзүүлэх дэмжлэг хэсэгт заасан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх;-Түүхийн хүрд кинонд:

Огноо	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл /сая.төгрөг/
2015 он	110,0	110,0
2016 он	110,0	110,0
2017 он	108,9	108,9
2018 он	108,9	108,9
2019 он	108,9	-
2020* он	120,0	-

Тайлбар: Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу Монгол улсын түүхэнд холбогдох онцлог үйл явдал, он дарааллын түүхийн талаархи баримтат кино бүтээх зардлыг улсын төсвөөс жил бүр санхүүжүүлж байна.

Өнөөгийн байдлаар төрийн бодлогоор зайлшгүй дэмжин авч явах 3 төрлийн кино бүтээл байдаг нь Баримтат кино, хүүхдийн кино, Монгол ёс заншлыг харуулсан Түүхэн сэдэвт уран сайхны кино юм. Одоогийн хэрэгжиж буй соёлын тухай хуулийн хүрээнд Баримтат кинонд жилд 50 сая, хүүхдийн кинонд 150 сая, түүхэн уран сайхны кинонд 110 сая төгрөгний дэмжлэг тус тус үзүүлж байна. Одоогоор зах зээл дээр хийгдэж буй бүрэн хэмжээний кино нь дунджаар 500 саяас 1 тэрбум төгрөгний санхүүжилтээр хийгдэж байгаа бөгөөд төрөөс үзүүлж буй дэмжлэг нь бодит дэмжлэг болж чадахгүй байгаа юм.

Кино бүтээх, киноны өртөгийн хамгийн өндөр зардал нь уран бүтээлчдийн цалин, киноны зураг авалтын байр, тоног төхөөрөмжийн түрээсийн зардал байдаг.

Манай улсад жилдээ 30-40 уран сайхны кино бүтээгдэж үзэгчдийн хүртээл болж байна. Жишээ болгон нэг киноны төсвийг авч үзвэл:

	Төсөвлөсөн зардлууд	Мөнгөн дүн / мян.төг /
1	Продакшн багийн зардал	180 000
2	Уран сайхны багийн зардал	24 000
3	Жүжигчдийн зардал	82 600
4	Зураглаачийн багийн зардал	16 000
5	Техник тоног төхөөрөмж төсөв	94 000
6	Зураачдын төсөв /тайз, байгууламж, хувцас/	50 000
7	Пиро техникийн зардал	90 000
8	Унаа тээвэр байрны зардал	8 000
9	Хүнсний зардал	6 000
10	Пост продакшны зардал	60 000
11	Маркетинг сурталчилгааны зардал	12 000
	Нийт зардлын дүн	622 600
	Нийт борлуулалт /кино театрууд-580,0 сая, Юнивижн, Скаймедиа-90,0 сая /	670 000
	Цэвэр ашиг	47 400

Нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө:

- Уг кинонд нийт 65 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан буюу 40 хүнийг ажлын байраар хангасан.
- НӨАТ-тэй бараа, үйлчилгээ худалдан авна,
- Улсын төсөвт 4,7 сая төгрөгийн ашиг төлнө,
- Монгол дүр төрхийг шингээсэн, хүүхдийн кино хийснээр хүүхэд залуучуудын хүмүүжилд эерэг нөлөө үзүүлэх, хүүхдийн хүүхдийн бүтээлч санааг хөгжүүлэх,

Мөн түүхэн сэдэвт кино нь өвөг дээдсийнхээ баатарлаг үйлсээр бахархах, залуу хойч үедээ түүхийг үнэн зөвөөр таниулах, нийгэмд эх оронч үзлийг төлөвшүүлэхэд ач холбогдолтой.

ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТООЦОО

№	Хуулийн заалт	Шаардагдах хөрөнгийн тооцоо, тайлбар
1	10.1.2 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдох орлогоос хасч тооцох	<p>Киноны салбарыг хөрөнгө санхүүгийн талаар дэмжсэн байгууллага, компани, хувь хүмүүст татварын болон бусад талын дэмжлэг үзүүлэх хууль эрх зүйн орчин байдаггүй, хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал нөхцөл байдлын улмаас түүхэн сэдэвт томоохон хэмжээний кино болон дорвитой уран бүтээл хийх санхүүгийн боломж хомс, хүүхэд залуучуудын хүмүүжил, ёс суртахуунд нөлөө үзүүлэхүйц чансаатай сайн бүтээлүүд ховор байна.</p> <p>Монгол улсын нутаг дэвсгэр дээр үндэсний кино үйлдвэрлэгч, бүтээгчдийн бүтээсэн монгол кинонд оруулсан хандив тусламжийг орлогын албан татвараас чөлөөлвөл:</p> <p>Тооцоолол</p> <p>Түүхэн сэдэвтэй уран сайхны кино бүтээхэд дундажаар 500,0-800,0 сая төгрөгийн өртөгтэй байдаг. Энэ киног бүтээхэд үндэсний компаниас 100,0 сая төгрөгийн хандив орж ирнэ. Хандиваар орж ирсэн орлогод татвар ногдуулахгүй бол улсын төсөвийн орлого 10,0 сая төгрөгөөр тасарна. Энэ үндэсний хэмжээний түүхэн киноны санхүүгийн эх үүсвэр нь улсын төсөв биш өөрийн хөрөнгө болон хандиваар бүтсэнээр тухайн кино бүтээгчийн орлого, кино театруудын орлого нэмэгдэж улсын төсөвт 20,0-50,0 сая төгрөг төвлөрөх боломж харагдаж байна. Мөн дэлхийн кино урлагийн салбарт гарч ирэх боломжтой байна. Түүхэн киногоор улс орноо сурталчлан таниулах, аялал жуулчлал нэмэгдэх, үр хойч үе маань Монголоор бахархах гэх мэт өөр бусад боломжууд</p> <p>2012 онд Монгол улсад кино тасалбарын нийт орлого 4,085.8 сая төгрөг байснаас 36% нь Монгол киноны борлуулалт байна.</p> <p>2014 онд нийт кино тасалбарын борлуулалт 9,500.0 сая төгрөг, үүнээс Монгол киноны орлого 44% буюу 4,180.0 сая төгрөг байгаа бөгөөд жилдээ 20-30 уран сайхны кино бүтээж үзэгч олондоо толилуулж байна. судалгаанаас харахад монгол киноны</p>

		<p>борлуулалт 2012 онтой харьцуулахад 184%-иар өссөн харагдаж байна.</p> <p>Нөгөө талаас татварын таатай нөхцлийг бүрдүүлж кино бүтээгчдийг дэмжсэнээр киноны борлуулалт 184 %-иар нэмэгдэж улсын төсөвт төвлөрөх татварын хэмжээ 418,0 сая төгрөгөөр өсч харагдаж байна.</p>
2	10.1.3 Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулах	<p>Үндэсний кино бүтээгчид Монгол улсын нутаг дэвсгэр дээр түүхэн ач холбогдолтой кино бүтээхэд дэмжлэг үзүүлж хөрөнгө оруулсан үндэсний компанийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцож татвараас чөлөөлвөл:</p> <p>Тооцоолол</p> <p>Үндэсний хэмжээний компани түүхэн ач холбогдолтой кинонд 100,0 сая төгрөгийн хандив өгснөөр тухайн компанийн улсын төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээ 10,0 сая төгрөгөөр буурах хэдий ч энэ кино бүтээл бий болж үзэгчдийн хүртээл болсноор улсын төсөвт 15,0 сая төгрөгийн татварын орлого төвлөрөх боломж харагдаж байна.</p>
3	10.1.4 Гаалийн татвараас 50 % хөнгөлнө.	<p>Үзэл баримтлалын ... р зүйлд заасан шаардалгыг хангасан кино үйлдвэрлэгч Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн кино бүтээх зориулалтын тусгай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд анги материалыг гаалийн албан татвараас 50% хөнгөлнө.</p> <p>Тооцоолол</p> <p>Кино үйлдвэрлэгч, бүтээгч компани нийт 100,0 сая төгрөгийн өртөгтэй сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжийг импортлоход гаалийн албан татварт 5,0 сая төгрөг төлнө. Гаалийн татвараас 50% хөнгөлснөөр улсын төсвийн орлогыг 2,5 сая төгрөгөөр тасалдуулж байгаа боловч дуу бичлэгийн өндөр түвшинд чанартай, дэвшилтэт технологээр үзэгчдийн хүртээл болсон кино бүтээснээр борлуулалтын орлого жилдээ 80%-иар нэмэгдэж эргээд улсын төсөвт 100,0-135,0 сая төгрөг төвлөрөх боломжтой байна.</p> <p>Монгол киног дэлхийн хэмжээнд гаргахын тулд үндэсний кино үйлдвэрлэгч, бүтээгчдээ технологийн дэвшилтэт тоног төхөөрөмжтэй болоход нь татварын хөнгөлөлттэй нөхцөлийг бүрдүүлэх</p>

		Ингэснээр кино нь техникийн болон уран сайхны хувьд өндөр түвшинд хүрч, киноны зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэж, үндэсний уламжлал, түүх, ёс заншлаа дэлхий нийтэд сурталчлах боломж нээлттэй болох юм.
--	--	---

**УЛСЫН ТӨСВӨӨС МӨНГӨ АВАХГҮЙГЭЭР ХУВИЙН СЕКТОРООС МӨНГӨ ТАТАХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛСАН КОМПАНИЙГ ШУУД БУС ЗАМААР ДЭМЖИХ БУЮУ
ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ**

Кино урлагаар дамжуулан үндэсний өв соёл, түүхээ сурталчлах, эрдэмтдийн судалгаанд суурилсан түүхэн баримтат бүтээл туурвих, түүхийг үнэн зөв талаас харуулах, дэлхий нийтэд сурталчлах, үндэсний киног дэлхийн киноны ололттой жишиглэн хөгжүүлэх, үндэсний болон олон улсын хэмжээнд ач холбогдолтой соёлын арга хэмжээ бүтээлийг санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, киноны салбарт төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг оновчтой болгож, үр ашгийг нь дээшлүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралт ТӨРИЙН ӨМЧИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТАНД Кино үйлдвэрийн үндэсний хүрээлэн байгуулах гэж орсон

Орчин үеийн техник, технологи бүхий кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг байгуулснаар маш олон ажлын байр бий болно, газар ашигласны төлбөр орж ирнэ, зочид буудал, хоолны газар, угаалгын газар гэх мэт маш олон ажлын байр бий болж байна.

Кино бүтээх, киноны өртөгийн хамгийн өндөр зардлыг уран бүтээлчдийн цалин, киноны зураг авалтын байр, тоног төхөөрөмжийн түрээсийн зардал байдаг.

Киног бүтээж үзэгчдийн хүртээл болгоход манайд чадварлаг уран бүтээлчид хангалттай байгаа, үзэгчид байгаа, үзвэрийн газар хөгжиж байгаа, харин кино үйлдвэрлэх техникийн бааз, тоног төхөөрөмж, павилонд хамаг зардлаа алдаж байна.

Аливаа хуулийн зохицуулалт төрийн байгууллагуудад тодорхой үйл ажиллагаа явуулах ачаалал үүсгэдэг. Зардлыг тооцоолохын үндсэн нөхцөл нь төрийн байгууллагаас ачаалал болж байгаа гүйцэтгэх ажлыг тодорхойлох, эдгээр ажил үйлчилгээний хэмжээг тогтоох буюу баримжаалах явдал байдаг. Дээрх хүснэгтээс үзэхэд хэдийгээр хуулийн төсөлд орсон шинэлэг зохицуулалт боловч ачаалал үүсгэн шинээр үүрэг хүлээлгээгүй гэж үзэж Засгийн газрын гүйцэтгэх үүрэг болох төслийн 4.1 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалт, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гүйцэтгэх үүрэг болох хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, мөн төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх үүрэг болох төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 дахь заалт, аймаг, нийслэлийн

Засаг даргын хүлээх үүрэг болох төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг хуулийн төслөөр тухайн байгууллагад ачаалал үүсгэх үүрэг биш гэж тооцлоо. Иймд төрийн байгууллагын гүйцэтгэж буй үүрэгт өөрчлөлт орсон, чиг үүрэг нэмэгдсэн зохицуулалт болох төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.4 дэх заалтууд, мөн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.5 дахь заалтад заасан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг сонгон авлаа.

Хүснэгт №2 – Үүргийн агуулга

ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА	ҮҮРЭГ	ҮҮРГИЙН АГУУЛГА
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	– Кино мэргэжлийн Зөвлөлийн ажиллах журам боловсруулж, батлах	журам боловсруулж, батлах
	– Тусгай зөвшөөрөл олгох – Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авах зөвшөөрөл олгох журам боловсруулж батлах	тусгай зөвшөөрөл олгох
Төрийн захиргааны байгууллага	– төрөөс санхүүжүүлсэн кинонд хяналт тавьж ажиллах	хяналт тавьж ажиллах
	– статистикийн мэдээллийг боловсруулж, дүн мэдээг нэгтгэх	статистикийн мэдээлэл боловсруулж, дүн мэдээг нэгтгэх
	– киноны мэдээллийн санг бүрдүүлэх	мэдээллийн санг бүрдүүлэх

Эдгээр ажил үйлчилгээг гүйцэтгэхэд тухайн байгууллагад ямар хэмжээний хүний нөөц шаардлагатай байгааг дараахь алхамаар тогтооно.

1.2. Хүний нөөцийг тогтоох

Хуулийн төслөөр төрийн байгууллагад үүрэг болгосон гүйцэтгэх тухайн ажил үйлчилгээг хийхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээ хэд байх вэ гэдгийг тогтооходоо:

1. Төрийн захиргааны байгууллагын ажилтнуудаас тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний цаг хугацааны зарцуулалт шаардагдах
2. Тухайн ажил үйлчилгээ хэдэн удаа хийгдэх буюу тохиолдлын тоог тооцон гаргах шаардлагатай.

Иймд төрийн байгууллагын гүйцэтгэж буй үүрэгт өөрчлөлт орсон, чиг үүрэг нэмэгдсэн зохицуулалт хуулийн төсөлд байгаа тохиолдлуудыг түүвэрлэж, аргачлалд заасны дагуу уг үүргийг хэрэгжүүлэхэд хийгдэх стандарт үйл ажиллагааг тодорхойлов.

Төрийн захиргааны байгууллагын ажилтнуудаас тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний цаг хугацааны зарцуулалт шаардагдахыг тооцоходоо стандарт үйл ажиллагааны загварыг⁵ ашиглалаа. Стандарт үйл ажиллагаа гэдэг нь үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд хийгдэх үйлдлүүд юм. Хэдийгээр үүрэг бүр өөрийн онцлогтой, тухайн үүргийн агуулгаас хамаараад ялгаатай үйлдэл хийгдэх боловч нийтлэг хийгдэх шинжээр нь тухайлбал "мэдээллийг нягтлах"

⁵ Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

байдлаар нь стандартчлан түүнд зарцуулах хугацааг нормчлон тогтоосон загвар⁶ болно. Үүргийн агуулгад хамаарах үйл ажиллагааг тодорхойлохдоо тухайн үүргийн агуулгад хамаарах үйлдлийг тодорхойлон бичиж “буюу” холбоосын араас стандарт үйл ажиллагаагаар илэрхийлснийг Хүснэгт №3 болон Хүснэгт №5-д үзүүлэв.

Хүснэгт №3 – Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /зарцуулах хугацаа/

ҮҮРГИЙН АГУУЛГА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа (мин) ⁷
Журам боловсруулж, батлах	Зохицуулах харилцаатай холбогдуулан судалгаа хийх буюу мэдээлэл цуглуулах	120
	Тухайн зохицуулах харилцаанд хамаарах субъект, объектыг тогтоох буюу боломжит хяналтын арга хэмжээг шалган мэдээлэл, өгөгдхүүнийг нягтлах	45
	Журмын төслийг хэлэлцүүлэх буюу дотоод зөвлөлгөөн хийх	30
	Алдааг засах буюу мэдээллийг нягтлах	10
	Журмыг батлуулах буюу мэдээлэл шилжүүлэх, нийтлүүлэх	10
НИЙТ		225 мин
Тусгай зөвшөөрөл олгох	Тусгай зөвшөөрөл хүсэх өргөдлийн маягт боловсруулах буюу мэдээлэл цуглуулах	120
	Маягтыг тараах буюу мэдээлэл шилжүүлэх, нийтлүүлэх	10
	Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн маягтыг хүлээж авах буюу мэдээлэл цуглуулах	15
	Маягтыг нягталж, шалгах буюу мэдээллийг нягтлах	45
	Шийдвэр гаргах буюу дотоод хуралдаан хийх	30
	Шийдвэрийг үндэслэн холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулах буюу мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах, зөвшөөрөл олгох	45
НИЙТ		265 мин

Хүснэгт № 4 - Төрийн захиргааны төв байгууллага /зарцуулах хугацаа/

ҮҮРГИЙН АГУУЛГА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа (мин) ⁸
Хяналт тавих	Мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах	45
	Шаардлагатай тохиолдолд дотоод хуралдаан хийх	30
Статистик мэдээлэл боловсруулж, дүн мэдээг нэгтгэх	Тоо баримтыг боловсруулах	15
	Алдааг засах	10
	Мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах	45
Мэдээллийн санг бүрдүүлэх	Мэдээлэл цуглуулах	15
	Мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах	5
	Алдааг засах	10
	Мэдээлэл шилжүүлэх ба нийтлүүлэх	10

⁶ Энэ талаар Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-аас дэлгэрэнгүй үзнэ үү.

⁷ Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг энгийн, дунд, бүрэн гэж ангилснаас “дунд”, “бүрэн” ангилалын хугацаагаар тооцов. Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

⁸ Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг энгийн, дунд, бүрэн гэж ангилснаас “дунд”, “бүрэн” ангилалын хугацаагаар тооцов. Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

Дээрх хүснэгтүүдээр хуулийн төсөлд тусгагдсан тухайн нэг ажил үйлчилгээг хийхэд нэг мэргэжилтэн зарцуулах нийт цагийг стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг ашиглан гаргалаа. Энэ ажил үйлчилгээ нийт хэдэн удаа хийгдэх боломжит тохиолдолын тоог тооцон гаргахад хуулийн төслөөр хүлээлгэсэн үүргийг биелүүлэхэд төрийн байгууллагын гүйцэтгэх ажил үйлчилгээний тохиолдолын тоог гаргах ёстой. Учир нь хүний нөөцийн тоог гаргахад дараах томъёог баримтлана.

Хүний нөөцийг тодорхойлох томъёо

Хүний нөөцийн тоо = Тухай бүр зарцуулах хугацаа * Тохиолдолын тоо

Тохиолдолын тоог тогтоох боломжтой, тогтоох боломжгүй үйл ажиллагаанууд байдгийг анхаарч, тооцоолох цаг хугацааны хүрээг нэг⁹ жил байна гэж тооцсон болно. Зорилго нь дээрх хэмжигдэхүүнүүдээр нэг жилд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тооцоолж гаргах явдал бөгөөд хүний нөөцийн хэрэгцээ буюу тухайн ажлыг гүйцэтгэх шаардлагатай ажилтны тоог баримжаалан гаргах явдал болно.¹⁰

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад заасан "...уран бүтээлийн төсөл болон хамтарсан кино бүтээхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий кино мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам батлах", 5.1.4 дэх заалтад заасан "Гадаад кино, хамтарсан кинонд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авах зөвшөөрөл олгох журам батлах" ажлууд тухайн нэг жилд тус бүр 1 удаа хийгдэнэ гэж тооцлоо. Иймд журам боловсруулж, батлуулах ажлын тохиолдолын тоо нийт 2 болно. Тохиолдолын тоог олж тогтоосон тул зарцуулагдах хугацааг тохиолдолын тоогоор үржүүлсэн дүнгээр хүн хүчний хэрэгцээ тодорхойлогдоно.

Хүснэгт №5 – Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /зарцуулах хугацаа/

ҮҮРГИЙН АГУУЛГА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа (мин) ¹¹	Тохиолдолын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/ мин
Журам боловсруулж, батлах	Зохицуулах харилцаатай холбогдуулан судалгаа хийх буюу мэдээлэл цуглуулах	120	2	240
	Тухайн зохицуулах харилцаанд хамаарах субъект, объектыг тогтоох буюу боломжит хяналтын арга хэмжээг шалган мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	45	2	90

⁹ Харьцуулах хугацааны нэгж нь 1 жил гэж тооцно.

¹⁰ 2010.04.14-ний өдрийн сургалтын үеэр тараасан материал Ex-ante аргачлал, хуудас 3-4

¹¹ Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг энгийн, дунд, бүрэн гэж ангилснаас "дунд", "бүрэн" ангилалын хугацаагаар тооцов. Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

	Журмын төслийг хэлэлцүүлэх буюу дотоод зөвлөлгөөн хийх	30	2	60
	Алдааг засах буюу мэдээллийг нягтлах	10	2	20
	Журмыг батлуулах буюу мэдээлэл шилжүүлэх, нийтлүүлэх	10	2	20
НИЙТ		225 мин		450 мин/60 мин = 7,5 цаг

Төрийн захиргааны албан хаагч нь 1 жилд 200 ажлын өдөр ажилладаг (тодруулбал: 1 жил 365 хоногтой бөгөөд үүнээс албан ёсны нийтээр амрах өдрүүд болон ээлжийн амралтын хугацааг дунджаар 15 ажлын өдөр гэж тооцож хасч тооцсон) гэж тооцлоо. Мөн 1 ажлын өдөр = 8 ажлын цаг, нийт 1600 цагийн ажлыг 1 жилд 1 төрийн албан хаагч ажиллах ёстой гэж үзэн хүний нөөцийн хэрэгцээ буюу тухайн ажлыг хийж гүйцэтгэх орон тоог гаргавал:

$7,5 \text{ цаг} / 1600 \text{ цаг} = 0,005$ хүний нөөцийн хэрэгцээ (орон тоо) шаардлагатай болно. Тодруулбал журам боловсруулж, батлах ажил хийхэд Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шинэ орон тоо, хүний нөөц шаардагдахгүй байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт кино түгээх үйл ажиллагаа явуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох талаарх хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэгт заасан байна. Өнөөдрийн байдлаар Нью тур Сафирс ХХК /Өргөө/, УБ синема ХХК /Тэнгис/, Соёмбо продакшн ХХК /Соёмбо/, Хүнү Молл ХХК, Гэгээнтэн интертаймент ХХК нар кино түгээх үйл ажиллагаа эрхэлж байна. Иймд тохиолдолын тоог 5 гэж авлаа.

Хүснэгт № 6 – Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /зарцуулах хугацаа/

ҮҮРГИЙН АГУУЛГА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа (мин) ¹²	Тохиолдолын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/мин
Тусгай зөвшөөрөл олгох	Тусгай зөвшөөрөл хүсэх өргөдлийн маягт боловсруулах буюу мэдээлэл цуглуулах	120	5	600
	Маягтыг тараах буюу мэдээлэл шилжүүлэх, нийтлүүлэх	10	5	50
	Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн маягтыг хүлээж авах буюу мэдээлэл цуглуулах	15	5	75
	Маягтыг нягталж, шалгах буюу мэдээллийг нягтлах	45	5	225
	Шийдвэр гаргах буюу дотоод хуралдаан хийх	30	5	150
	Шийдвэрийг үндэслэн холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулах буюу мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах, зөвшөөрөл олгох	45	5	225

¹² Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг энгийн, дунд, бүрэн гэж ангилснаас "дунд", "бүрэн" ангилалын хугацаагаар тооцов. Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

НИЙТ	265 мин	1352 мин /60 мин = 22 цаг
------	---------	---------------------------

Тухайн ажилд 22 цаг зарцуулна гэж үзэн тухайн 1 жилд 1 ажилтан 1 жилд 1600¹³ цаг ажиллана гэвэл:

22 цаг /1600 цаг = 0,01 хүний нөөцийн хэрэгцээ (орон тоо) шаардлагатай болно. Тодруулбал кино түгээгчид тусгай зөвшөөрөл олгоход Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 0,01 хүний нөөц шаардагдахаар байна.

Төрийн захиргааны төв байгууллагын тухайд хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т зааснаар төрөөс санхүүжүүлсэн кинонд хяналт тавьж ажиллах бөгөөд тухайн жилд уг ажиллагаа хийгдэх тохиолдолын тоог "4" гэж авав. Учир нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн¹⁴ 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу уг үүргийг хүлээж байгаа бөгөөд төсөвт тусгах, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах ажлыг Төсвийн тухай хуулийн¹⁵ 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж тайлагнана.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д киноны салбарын дүн мэдээг нэгтгэх, статистик мэдээлэл боловсруулах, киноны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбоотой тохиолдолын тоог тодорхойлохдоо тухайн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагаа тайлагнадаг тоогоор буюу Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн¹⁶ 10 дугаар зүйлийн 10.4-т зааснаар тухайн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлыг төлөвлөх, тайлагнах хугацаа, тоог тусгах зохицуулалттай тул нийтлэг байдлаар "хагас жил, жил" гэж үзэн тохиолдолын тоог "2" гэж авлаа.

Хүснэгт №7 – Төрийн захиргааны төв байгууллага /зарцуулах хугацаа/

ҮҮРГИЙН АГУУЛГА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа (мин) ¹⁷	Тохиолдолын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/мин
Хяналт тавих	Мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах	45	4	180
	Шаардлагатай тохиолдолд дотоод хуралдаан хийх	30	4	120
Статистик мэдээлэл боловсруулж, дүн мэдээг нэгтгэх	Тоо баримтыг боловсруулах	15	2	30
	Алдааг засах	10	2	20
	Мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах	45	2	90
Мэдээллийн санг бүрдүүлэх	Мэдээлэл цуглуулах	15	1	15
	Мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах	5	1	5
	Алдааг засах	10	1	10

¹³ 1 жилд 200 ажлын өдөр байдаг гэж тооцвол 1 өдөр = 8 ажлын цаг, нийт 1600 цаг 1 жил 1 албан хаагч ажиллах ёстой.

¹⁴ <http://www.legalinfo.mn/law/details/271?lawid=271>

¹⁵ <http://www.legalinfo.mn/law/details/12254?lawid=12254>

¹⁶ <http://www.legalinfo.mn/law/details/271?lawid=271>

¹⁷ Стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг энгийн, дунд, бүрэн гэж ангилснаас "дунд", "бүрэн" ангилалын хугацаагаар тооцов. Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

	Мэдээлэл шилжүүлэх ба нийтлүүлэх	10	1	10
НИЙТ		185 мин		480 мин/60 мин = 8 цаг

Төрийн захиргааны байгууллага нь дээрх ажилд 8 цаг зарцуулна гэж үзэн тухайн 1 жилд 1 ажилтан 1 жилд 1600¹⁸ цаг ажиллана гэвэл:

8 цаг /1600 цаг = 0,005 хүний нөөцийн хэрэгцээ (орон тоо) шаардлагатай болно. Тодруулбал хуулийн төслийн 6 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагад 0,005 хүний нөөц шаардагдах тооцоолол гарч байгаа нь төрийн захиргааны байгууллагад шинэ орон тоо, хүний нөөц шаардагдахгүй байгааг харуулж байна.

Хүснэгт №8 –Нэмэгдэж буй ачаалал

БАЙГУУЛЛАГА	Хүний нөөцийн хэрэгцээ /цаг	Жилд шаардагдах ажлын цаг	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	7,5 цаг	1600	0,005
	22 цаг	1600	0,01
НИЙТ			0,015
Төрийн захиргааны төв байгууллага	8 цаг	1600	0,005
	НИЙТ		0,005

1.3 Гарах зардлыг тооцох

Зардлын тооцоог гаргахдаа дараахь 3 төрлийн зардал гарна гэж тооцов¹⁹.

1. Хүний нөөцийн буюу боловсон хүчний зардал
2. Материаллаг зардал
3. Бусад зардал

1.3.1. Хүний нөөцийн зардал

Төрийн байгууллагын зардлын дийлэнхийг хүний нөөцийн зардал эзэлдэг. Тодруулбал тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох бүх нэмэгдэл, тусламж, төрөөс даадаг бүх зардлыг энд тооцно. Эдгээрийг нэгтгэн дундажаар гаргасан зардалыг хүний нөөцийн зардал гэх бөгөөд үүнийг дараахь байдлаар томъёолон үзүүлж болно.

Хүний нөөцийн буюу боловсон хүчний дундаж зардал			
=			
Шууд зардал + Нийтлэг зардал + Дагалдах зардал+ Нэмэгдэл зардал			
Цалин (цалингийн сүлжээнээс ²⁰ дундажлах)	дундаж цалингийн 15%	дундаж цалингийн 10%	дундаж цалингийн 30%

¹⁸ 1 жилд 200 ажлын өдөр байдаг гэж тооцвол 1өдөр= 8 ажлын цаг, нийт 1600 цаг 1 жил 1 албан хаагч ажиллах ёстой.

¹⁹ Ху 284

²⁰ МОНГОЛ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ, ДООД ЖИШГИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ 2014 оны

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх боловсон хүчин буюу албан тушаалтанд дараахь шууд зардал төрөөс гардаг гэж үзлээ.

Хүснэгт №9

БАЙГУУЛЛАГА	Үйл ажиллагаа	Үүрэг хүлээгч	Цалингийн сүлжээний дагуу	Дундаж цалин /төг/
Төрийн захиргааны байгууллага	төрөөс санхүүжүүлсэн кинонд хяналт тавьж ажиллах статистикийн мэдээллийг боловсруулж, дүн мэдээг нэгтгэх, киноны мэдээллийн санг бүрдүүлэх	Мэргэжилтэн	ТЗ-6 ²¹ /1-5 зэрэглэл/	662068
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	журам боловсруулж, батлуулах, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой ажиллагаа хийх	Мэргэжилтэн	ТЗ-7 ²² /1-5 зэрэглэл/	716054

Хүснэгт №10 -Үүрэг хүлээгч тус бүрээр дундаж зардал /төг/

Үүрэг хүлээгч албан тушаалтан	Шууд зардал	Нийтлэг зардал	Дагалдах зардал	Нэмэгдэл зардал	Боловсон хүчний дундаж зардал
	Дундаж цалин	15%	10%	30%	
Мэргэжилтэн Т36	662068	99310	66207	198620	1026205
Мэргэжилтэн Т37	716054	107408	71605	214816	1109883

Дээрх хүснэгтэд тухайн чиг үүргийг хүлээж байгаа төрийн байгууллагын ажил үйлчилгээг гүйцэтгэх нэг боловсон хүчинд (мэргэжилтэн, албан тушаалтан) оногдох зардал гарсан. Энэ зардалыг өмнө нь тооцон гаргасан хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэхэд хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт №11 -Хүний нөөцийн нийт зардал

БАЙГУУЛЛАГА	Нэмэгдэж буй ачаалал	Боловсон хүчний дундаж зардал	Хүний нөөцийн нийт зардал /төг/
Төрийн захиргааны байгууллага	0,005	1026205	5131
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	0,015	1109883	16648
НИЙТ			21779

Хүний нөөцийн нийт зардал нь 21779 буюу хорин нэгэн мянга долоон зуун далан есөн төгрөг болно.

1.3.2. Материаллаг зардал – тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардалыг хэлнэ. Тухайлбал цахилгааны зардал, техник тоног төхөөрөмжийн зардал, бичиг хэргийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал орох бөгөөд бүгд

²¹ Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралт: Т36-1 /591580/, Т37-2 /627167/, Т37-3 /662762/, Т37-4 /697200/, Т36-5 /731631/

²² Мөн тэнд Т37-1 /638516/, Т37-2 /677663/, Т37-3 /716818/, Т37-4 /754699/, Т37-5 /792572/

нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ. Гэвч дээрх бүх зардалыг нарийн тооцоолоход шаардагдах зардалууд санхүүгийн тайланд тусгагдсан боловч нарийвчлан заагаагүй байх тул материаллаг зардал, ажлын байрны зардлын жишээг “Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д үзүүлсэн ХЗДХЯ-ны нэг ажилтны материаллаг зардалыг тооцсон жишээгээр авав.²³

Урсгал зардал

- Бичиг хэргийн зардал -124,000
 - Ном хэвлэл авах -54,745
 - Шуудан, холбоо – 306,812
- НИЙТ = 485,557 төг**

Барилга, байгууламж, өрөө тасалгааны тооцоот зардал

- Түлш, халаалт – 263,408
 - Гэрэл цахилгаан - 128,239
 - Цэвэр, бохир ус – 599,438
 - Урсгал засвар – 127,752
 - Газрын төлбөр – 22,253
- НИЙТ = 1,141,090 төг**

Элэгдэл хорогдолын зардал²⁴ - нэг мэргэжилтэнд ногдох хэмжээг гол үзүүлэлт болгон авсан.

- техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800.000 төг гэж тооцоход элэгдэл хорогдол нь үүний 20%²⁵ буюу 160.000 төг
- хэрэглэж буй ширээ, сандал, шүүгээ, утасны аппаратны үнэ дундажаар 1.000.000 төг гэж тооцоход элэгдэл хорогдол нь үүний 10%²⁶ буюу 100,000 төг

НИЙТ = 260.000 төг

Дээрх бүгд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ.

Ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал
=
Урсгал зардал + Барилга, байгууламж, өрөө тасалгааны тооцоот зардал + Элэгдэл хорогдолын зардал

485,557 + 1,141,090 + 260,000 = 1,886,647 төг
(Материаллаг зардал)

²³ ХЗЯ, GIZ, Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал, УБ, 2012, ху 97

²⁴ Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдэлийн хэмжээ

²⁵ Мөн тэнд, 2 дугаар хавсралт “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдэлийн хэмжээ”, 18. Нийтийн аж ахуй, үйлчилгээний тоног төхөөрөмж, 91. Тооцоолон бодох техник хэрэгсэл – 1 жилд байгуулах элэгдэлийн хэмжээ

²⁶ Мөн тэнд, 2 дугаар хавсралт “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдэлийн хэмжээ”, 18. Нийтийн аж ахуй, үйлчилгээний тоног төхөөрөмж, 95. Тавилга эд хогшил– 1 жилд байгуулах элэгдэлийн хэмжээ

1.3.3. Бусад зардал – Бусад зардалд төрийн байгууллагаас үүрэг биелүүлэхэд буюу хуулийн төслөөр үүрэг болгосон ажил үйлчилгээ гүйцэтгэхэд гарах зардлыг биш, харин тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал хамаарна. Хуулийн төслийн зохицуулалтаар тусгай тоног төхөөрөмж суурилуулах, ашиглахтай холбоотой ажил үйлчилгээг тодорхойлж өгөөгүй тул төрийн байгууллагуудад дагалдан гарах зардал байхгүй гэж үзэв.

1.4.Зардлыг нэгтгэн тооцож гаргах

Дээр тооцсон зардалуудын нийт дүн 1908426 буюу нэг сая есөн зуун найман мянга дөрвөн зуун хорин зургаан төгрөгтэй тэнцэж байна. Үүнийг дор хүснэгтээр харуулав:

		Хүснэгт №12 – Нийт зардал
	1. Хүний нөөцийн нийт зардал	21779 төг
+	2. Материаллаг зардал	1,886,647 төг
	3. Бусад зардал	0 төг
ЗАРДАЛ		1,908,426 төг

1.5.Хувилбарыг нягтлах, үр дүнг танилцуулах

Ийнхүү зардлын тооцоо хийхийн гол зорилго хуулийн төслийн хүрээнд төрийн захиргааны байгууллагад шинээр бий болж байгаа үүргээс үүдэлтэй ачааллыг эхнээс нь аль болох хөнгөн байлгахад оршино. Иймд эрх зүйн тухайн зохицуулалт буюу бэлтгэж буй төсөлд альтернатив байна уу гэдгийг шалгаж үзэх нь чухал байдаг.

Кино урлагийг дэмжих тухайн хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг буюу олон улсын кино наадам, арга хэмжээг эх орондоо зохион байгуулах ажлыг улсын төсөвт ачаалал үүсгэхгүйгээр хийх, тухай бүр асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэх боломж нөхцөл байгаа эсэхийг судлах нь зүйтэй гэж үзэж байна.

2.ХУУЛИЙН ЭТГЭЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Кино урлагийг дэмжих тухайн хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “Улсын төсвөөс санхүүжилт авч кино бүтээсэн иргэн, хуулийн этгээд нь санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж Соёлын асуудал эхрэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”-ийг үүрэг болгосон байна. Тус үүргийг хэрэгжүүлэхийн тулд мэдээлэх үүрэг болон зарцуулах хугацааг зайлшгүй хийгдэх үйлдэлийн стандарт үйл ажиллагаагаар тооцов.²⁷

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа тухайн хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж ажилтанд олгох сарын үндсэн цалин, сард ажиллах хугацааг тодорхойлж гаргана.

²⁷ Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

Ажлын хөлс = Үндсэн цалин /Ажиллах хугацаа

Үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааж тухайн ажиллагааг хийж байгаа ажилтанд ногдох ажлын хөлсийг гаргаж тооцлоо. Тодруулбал кино үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд ажиллаж буй ажилтанг Монгол кино нэгтгэл ТӨҮГ²⁸-д баримталж буй цалингийн жишгээр тооцов. Соёл урлагийн салбарт ажиллаж буй ажилтны сарын үндсэн цалинг 600,000 төгрөгтэй тэнцэнэ гэж үзлээ. Ажиллах хугацааны тухайд Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд ажлын цагийг долоо хоногийн ажлын цаг нь 40, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна. Тиймээс ажилтан сард ажиллах хугацаа нь 22 хоног буюу 176 цаг /22*8 цаг/ байна. 176 цагийг минутад шилжүүлбэл 10560 минут гэж тооцлоо.

$$600,000 \text{ төг} / 10560 \text{ мин} = 56,8 \text{ төг/мин}$$

Тохиолдолын тоо гэдэг нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгаагаар илэрхийлнэ. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр кино зураг авах, дүрс бичлэг хийх, кино үйлдвэрлэл явуулах аж ахуйн нэгжүүдийн тоог таамаглах арга хэрэглэлээ. Тодруулбал улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн статистик мэдээг харгалзан таамаг тохиолдолын тоо гаргахыг зорив. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн²⁹ 15 дугаар зүйлд зааснаар 15.7 дахь хэсэгт заасан боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр 10 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог гэдгийг харгалзан кино үйлдвэрлэл явуулах аж ахуйн нэгжийн тоог нийт бүртгэлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 10%-тай тэнцэнэ гэж тооцвол кино үйлдвэрлэлийн салбарт 1372 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг гэж таамаглалаа. Үүнээс улсын төсвөөс санхүүжилт авч кино бүтээх хуулийн этгээдийн тоо нийт кино үйлдвэрлэлийн салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй хэсэг буюу 0,01%-тай тэнцэнэ гэж үзвэл тохиолдолын тоог 13.7 буюу 14 гэж тооцсон.

**Хүснэгт № 13 – Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн статистик мэдээ³⁰
/2018 оны 08 дугаар сарын байдлаар/**

	Өмнөх оны мөн үе	Жилийн эхнээс өссөн дүнгээр	Тайлант сарын дүн	Кино үйлдвэрлэл явуулах хуулийн этгээд	Төрөөс санхүүжилт авч кино хийх хуулийн этгээд
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	125782	137209	1007	1372	14

Давтамжийг хуулийн төсөлд тодорхойлоан заагаагүй байх тул 1 жилд 1 удаа хийгдэх ажил үйлчилгээний давтамж гэж авч үзэв.

Захиргааны зүгээс үзүүлэх ачааллыг дараах томъёогоор тооцож олно.

²⁸ <http://mongol-kino.mn/>

²⁹ <http://legalinfo.mn/law/details/34?lawid=34> -

³⁰ <http://burtegel.gov.mn/index.php/news/statistical-rating-item/2214-2018-08> - нэвтэрсэн огноо 2018.10.31-ний өдөр

Хугацаа (мин)*Тохиолдлын тоо*Давтамж = Захиргааны зүгээс үзүүлэх ачаалал

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу хуулийн этгээдэд үүрэг болгосон ажлыг хийж гүйцэтгэхэд үүсэх захиргааны зардлыг дараах хүснэгтэд тооцож гаргав.

Хүснэгт №14 – Хуулийн этгээдэд үүсэх захиргааны ачааллын тооцоо буюу тоон үзүүлэлт

Мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Ажлын хөлс (төг/мин)	Тохиолдлын тоо	Давтамж	Захиргааны зүгээс үзүүлэх ачаалал
санхүүгийн тайлан гаргах	тайлан мэдээг бэлтгэх буюу тоо баримтыг боловсруулах	120	56,8	14	1	95424
	мэдээлэл өгөгдхүүнийг нягтлах	45	56,8	14	1	35784
	Алдааг засах	60	56,8	14	1	47712
	Мэдээлэл нийтлүүлэх буюу тайланг хэвлэх	10	56,8	14	1	7952
тайлангаа аудитаар баталгаажуулах	Мэдээлэл шилжүүлэх	10	56,8	14	1	7952
	Тайлангийн талаарх дүгнэлтийг хүлээн авах, тэмдэглэх	30	56,8	14	1	23856
	Тооцоо хийх буюу мөнгө шилжүүлэх	30	56,8	14	1	23856
НИЙТ						242536

Шаардлагатай тохиолдолд үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах нэмэлт зардлыг тооцдог. 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Шуудан ХК-ийн тарифаас үзэхэд 20 гр албан бичгийг хот дотор хүргэхэд 1100 төг, харин орон нутаг руу илгээхэд 1980 төг байна. Иймд тайланг хүргүүлэх шуудангийн зардлыг дунджаар 1540 төг гэж тооцов. Олшруулах, хувилах зардал ихэнх тохиолдолд тухайн байгууллагын дотоод зардалд тооцогддог боловч энэ төрлийн ажиллагаа хийхэд зах зээл дээрх үнэ ханшийг жишиг болгон тооцлоо. Тодруулбал 1 нүүр албан тайлан хувилах зардал 100 төг гэж тооцвол тайланг гаргах маягтуудын тоог үндэслэн дунджаар 1000 төг гэж зардлыг тооцов. Доорх хүснэгтээр нэмэлт зардлын тооцоог үзүүлэв.

Хүснэгт №15 - Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд үүсэх /нэмэлт/ зардлын тооцоо

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүсч болох нэмэлт зардал	Зардлын хэмжээ /төг/	Тоон үзүүлэлт	Нийт нэмэлт зардал /төг/
-----	-----------------	--------------------------	----------------------	---------------	--------------------------

1	Улсын төсвөөс санхүүжилт авч кино бүтээсэн иргэн, хуулийн этгээд нь санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж Соёлын асуудал эхрэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	Аудитаар баталгаажсан тайланг олшруулах зардал	1000 төг	795,2	795200
		Тайланг хүргүүлэх шуудангийн зардал ³¹	1540 төг	795,2	1224608
НИЙТ					2019808

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ НИЙТ ЗАРДАЛ

НИЙТ ЗАРДАЛ	242,536
+	+
НЭМЭЛТ ЗАРДАЛ	2,019,808
=	=
ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ	2,262,344

3. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн улмаас иргэдийн хувьд санхүүгийн нэмэлт ачаалал үүсэхээр байгаа эсэхийг тооцон гаргахыг зорив.³² Хуулийн төсөл дэх зохицуулалтаар төрийн байгууллагын зүгээс иргэнд мэдээллийн үүрэг оногдуулсны улмаас үүсэх ачаалал, түүнтэй холбогдон гарах зардлыг тооцоолоход дараахь үе шатуудыг баримталлаа. Үүнд:

1. Мэдээлэх үүргүүдийг тогтоох
2. Цаг хугацааны зарцуулалт болон гарч болох зардлыг тооцох
3. Тоон үзүүлэлтүүдийг тооцох
4. Нийт дүнг тооцож гаргах

3.1 Мэдээлэх үүргүүдийг тогтоох

Иргэний хүлээх мэдээлэх үүрэг гэдэг бол хуулийн төсөлд томъёологдсон эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалтаар тоо баримт, бусад мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэхийг хэлнэ. Түүнчлэн бүх төрлийн зөвшөөрөл олгох тухай, эсхүл баримт бичиг, тодорхойлолт авах тухай өргөдөл, аливаа бүртгэлд бүртгүүлэх хүсэлт, маягт, статистик, тэрчлэн тэмдэглүүлэн нотлох болон баримтжуулах үүргүүд мэдээлэх үүрэгт хамаарна.³³

³¹ Харилцаа холбооны зохицуулах хороо нь шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын шинээр мөрдөх үнэ тарифын тооцоог Монгол улсын шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д заасан бүрэн эрхийн дагуу үндэслэлийг хянан, дээд, доод хязгаарыг баталж өгдөг.

³² Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 261

³³ Мөн тэнд

Мэдээлэх үүргийг Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөлд дараахь байдлаар тусгасныг доор хүснэгтээр үзүүлээ:

Хүснэгт №16 – Иргэний мэдээлэх үүрэг

Хуулийн төсөл дэх зохицуулалт	Иргэний мэдээлэх үүрэг
<p>8 дугаар зүйл. Кино бүтээх үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг</p> <p>8.1. Кино бүтээх үйл ажиллагаанд оролцогч нь дараах үүрэг хүлээнэ:</p> <p>8.1.3. Улсын төсвөөс санхүүжилт авч кино бүтээсэн иргэн, хуулийн этгээд нь санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж Соёлын асуудал эхрэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p>	<p>Санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж Соёлын асуудал эхрэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.</p>

3.2. Цаг хугацааны зарцуулалт болон гарч болох зардлыг тооцох

Иргэдэд хамаарах мэдээлэх үүрэг нь чухам ямар утга агуулж байгаа, тэдгээрийг биелүүлэхийн тулд ямар ямар үйл ажиллагааг (стандарт үйл ажиллагаа гэгдэх) нэг бүрчлэн гүйцэтгэхийг тодорхойлсны үндсэн дээр тухайн ажлыг хийхэд зарцуулах хугацааг, хэдэн удаа хийгдэх үйлдэл (давтамж) гэдгийг тогтоож зардлыг тооцлоо.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад зааснаар улсын төсвөөс санхүүжилт авсан иргэн нь санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж Соёлын асуудал эхрэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэг хүлээж байгаа бөгөөд санхүүгийн тайлан гаргахдаа тодорхой стандарт буюу журмыг баримтална.

3.3. Тоон үзүүлэлтүүдийг тооцох

1 иргэнийг 1 тохиолдолд гэж тооцвол улсын төсвөөс санхүүжилт авч кино бүтээх иргэдийн тоог энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн 10%-тай тэнцэнэ гэж таамаглавал $14 \times 0,1 = 1,4$ тохиолдол гэж тооцлоо.

Хүснэгт №17 - Тоон үзүүлэлтүүд

Мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдолын тоо	Давтамж
Санхүүгийн тайлан гаргах	Маягт бөглөх	3 мин	1,4	1
	Нягтлах	10 мин	1,4	1
Тайлан аудитаар баталгаажуулах	Мэдээлэл шилжүүлэх	10 мин	1,4	1
	Тайлангийн талаарх дүгнэлтийг хүлээн авах, тэмдэглэх	30 мин	1,4	1
	Тооцоо хийх буюу мөнгө шилжүүлэх	30 мин	1,4	1
Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Олшруулах	2 мин	1,4	1
	Илгээх хүргэж өгөх эсхүл шууданд хийх	15 мин	1,4	1
НИЙТ		100 мин	1,4	1

Иргэний мөнгөн зарцуулалт буюу түүнд үүсч буй зардлыг доорх томъёогоор тооцов.

**Тохиолдолын тоо*Давтамжийн тоо* тухайн нэгж стандарт үйл ажиллагааг
гүйцэтгэхэд гаргасан мөнгөн зарцуулалт
=
Зардал**

Үүнд тухайн мөнгөн зарцуулалт гэдэгт тухайн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцдог. 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Шуудан ХК-ийн тарифаас үзэхэд 20 гр албан бичгийг хот дотор хүргэхэд 1100 төг, харин орон нутаг руу илгээхэд 1980 төг байна. Иймд тайланг хүргүүлэх шуудангийн зардлыг дунджаар 1540 төг гэж тооцов. Олшруулах, хувилах зардал ихэнх тохиолдолд тухайн байгууллагын дотоод зардалд тооцогддог боловч энэ төрлийн ажиллагаа хийхэд зах зээл дээрх үнэ ханшийг жишиг болгон тооцлоо. Тодруулбал 1 нүүр албан тайлан хувилах зардал 100 төг гэж тооцвол тайланг гаргах маягтуудын тоог үндэслэн дунджаар 1000 төг гэж зардлыг тооцов.

	Зарцуулах хугацаа	Тохиолдолын тоо	Давтамж	Нэгж үнэ /төг/	Зардал /төг/
Олшруулах	2 мин	1,4	1	1000	2800
Илгээх хүргэж өгөх эсхүл шууданд хийх	15 мин	1,4	1	1540	32340
НИЙТ					35140

3.4.Нийт дүн

Эрх зүйн зохицуулалт	
Мэдээлэх үүрэг нэг бүр	
Мэдээллийн агуулга нэг бүр	
Шаардагдах захиргааны үйл ажиллагаа (Стандарт үйл ажиллагаа)	
Цаг хугацаа	Тохиолдолын тоо х Давтамж
Захиргааны үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа	Захиргааны үйл ажиллагааны тоо
Захиргааны зүгээс үзүүлэх ачаалал = Цаг хугацаа * Тоо	

Тухайн нэг иргэнд 35140 төгрөгийн зардал хуулийн төсөлд заасан чиг үүргийг биелүүлэх хүрээнд үүснэ.

-o000o-